

Нэг. Ерөнхий мэдээлэл, Мэдээлэл цуглуулах

“Odo” цахим худалдааны платформ (веб, апп, платформыг нэгтгэн цаашид “Платформ” гэх) нь дараах тохиолдлуудад иргэн, хуулийн этгээдийн /цаашид “Хэрэглэгч”/ мэдээллийг цуглуулна. Үүнд:

1. Хэрэглэгч гэдэг нь Odo.mn вэб, Odo Shop апп, Платформд нэвтрэх, өөрийн бүртгэлийг үүсгэн бараа бүтээгдэхүүн захиалж буй хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
2. Хэрэглэгч платформд бүртгүүлэх үед цахим шуудангийн хаяг болон Хэрэглэгчийн үүсгэсэн нууц үг платформд хадгалагдана. Хэрэглэгчийн оруулсан нууц үгийг платформ шифрлэн кодчилж хадгалах учир Хэрэглэгчээс өөр хэн ч нууц үгийг мэдэх боломжгүй юм.
3. Хэрэглэгч хувийн мэдээллээ оруулах үед мэдээлэл (өөрийн овог нэр, хаяг байршил гэх мэт ерөнхий мэдээллүүд) платформд хадгалагдана.
4. Хэрэглэгчийн платформд хийсэн дараах үйлдлүүдийн мэдээлэл (таны хувийн мэдээлэл, захиалгын мэдээлэл, сонирхож буй бараа бүтээгдэхүүний мэдээлэл гэх мэт) платформд хадгалагдана.
5. Хэрэглэгч FACEBOOK хаягаараа Odo.mn цахим худалдааны платформд бүртгэл үүсгэсэн бол Хэрэглэгчийн мэдээллийг FACEBOOK–с авах бөгөөд (Овог, Нэр, Цахим шуудан, Хаяг байршил гэх мэт) Хэрэглэгчийн нийтэд ил болгохыг зөвшөөрсөн мэдээллүүд платформд хадгалагдаж Хэрэглэгч платформд нэвтрэх нууц үг оруулснаар хэрэглэгч болно.

Хоёр. Хэрэглэгчийн мэдээллийг ашиглах нөхцөл

Платформын үндсэн зааварчилгааны дагуу Хэрэглэгчийн оруулсан мэдээлэл нь Хэрэглэгчийн өмч бөгөөд “Одо экосистемс” ХХК Хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр дор дурдсан нөхцөлөөс бусад хэлбэрээр ашиглахгүй болно.

1. Захиалсан бараа бүтээгдэхүүнийг хүргэх, захиалгатай холбоотой тодруулах зүйл гарсан тохиолдолд таны мэдээллийг дараах байдлаар ашиглана. Үүнд: таны гар утсанд холбогдох, цахим шууданд мэдээлэл илгээх, хэрэглэгчийн бүртгүүлсэн хаягаар хүргэлт хийх гэх мэт.
2. Платформын ашиг тусын тулд системийн хяналт, сайжруулалт, хөгжүүлэлт, тест хийх
3. Шинэ бүтээгдэхүүн ба модуль хөгжүүлэх болон тест хийх
4. Техникийн засвар хийх
5. Платформын судалгаа ба хяналтад зориулж (нийт хэрэглэгч, захиалга гэх мэт)
6. Хэрэглэгчид шинэ бүтээгдэхүүн, хямдралын мэдээллийг хүргэх зориулалтаар тус тус.

Гурав. Хэрэглэгчийн мэдээллийг бусдад түгээх

“Одо экосистемс” ХХК нь Хэрэглэгчийн хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд ашиглуулахгүй, түгээхгүй, худалдахгүй бөгөөд үйлчилгээний хэрэгцээнээс гадуур аливаа ашиг олох зорилгоор ашиглахгүй болно.

Дөрөв. Хэрэглэгчийн мэдээллийг хадгалах

1. “Одо экосистемс” ХХК нь Хэрэглэгчийн платформд оруулсан мэдээллийг Мобинет компанийн дата центр дэх өөрийн серверт хадгална. Хэрэглэгч нь платформд нэвтрэх нэр, нууц үгийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй.
2. Нэвтрэх эрхээ бусдад алдсанаас үүдэлтэй Хэрэглэгчийн хуудаст үүссэн аливаа хор, хохирлыг “Одо экосистемс” ХХК хариуцахгүй болно. “Одо экосистемс” ХХК нь Хэрэглэгчийн хандах эрхийг ашиглан мэдээлэлд нэвтрэх боломжгүй болохыг анхааруулж байна.

Тав. Хэрэглэгч мэдээллээ удирдах

1. Хэрэглэгч хувийн мэдээлэл болон өөрийн дансныхаа тохиргоог хэдийд ч өөрчлөх боломжтой.
2. Хэрэглэгч системийн цахим шуудан (и-мэйл) үйлчилгээнээс өөрийгөө хасуулах боломжтой.
3. Хэрэв хэрэглэгч өөрийн эрхээ идэвхгүй болгосон бол хэрэглэгчийн мэдээллийг платформд ил гаргаж харуулахгүй. Платформ нь хэрэглэгчийн мэдээллийг хэрэглэгч идэвхтэй горимд орох хүртэл хадгална.

Зургаа. Нууцлалын бодлогын шинэчлэлт

1. “Одо экосистемс” ХХК нь Нууцлалын бодлогод өөрчлөлт оруулах эрхтэй. Нууцлалын бодлогод өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр Odo.mn сайт дээр нийгэд нээлттэй нийтлэх бөгөөд Хэрэглэгч нь танилцах үүрэг хүлээнэ.
2. Хэрэглэгчийг захиалга хийх үед хүчинтэй байсан “Нууцлалын бодлого” захиалгыг хүргэх шатанд өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх “Нууцлалын бодлого”-г бараа бүтээгдэхүүнийг хүлээж авах хүртэлх хугацаанд хүчинтэйд тооцно.